



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 40

Арвайхээр

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү, хэмжээ,
тэргүүлэх чиглэлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 1.8, 3.1.2, 3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Сум хөгжүүлэх сангаас олгох хөнгөлттэй зээлийн хүүгийн хэмжээг 2018 онд 3 хувь, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг ерх иргэнд 10000.0 /Арван сая/ төгрөг хүртэл 36 сар, Аж ахуйн нэгжид 40000.0 /Дөчин сая/ хүртэл 36 сар байхаар тус тус тогтоосугай.

2. 2018 онд тэргүүлэх чиглэлээр:

- 2.1 Өрхийн үйлдвэрлэл
- 2.2 Ноос ноолуур, арьс шир, сүлжмэл, зэрмэлийн үйлдвэр
- 2.3 Хог хаягдал болон дахин боловсруулах үйлдвэр
- 2.4 Эрчимжсэн аж ахуй, газар тариалан, жимс жимсгэний аж ахуй
- 2.5 Сав, баглаа боодлын үйлдвэр
- 2.6 Үйлдвэр үйлчилгээ
- 2.7 Ахуйн үйлчилгээний чиглэлээр тус тус тогтоосугай.

3. Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг баримтлан, зээлийн эргэн төлөлт, ажлын байр шинээр бий болгох, төсөл хэрэгжих баталгаа үндэслэл, тооцоо зэргийг харгалзан төслүүдийг сонгон шалгаруулж, зээлийг олгон, явц үр дүнг хагас, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг зөвлөлийн дарга /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

4. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 сарын 06-ны өдрийн 20 дугаар тогтоолыг 2018 оны 11 сарын 13-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА 

Д.АМАРТУВШИН